



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/250

Улаанбаатар хот

### Нийслэлийн Өмчийн харилцааны газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд нийт 17,474,370.00 (арван долоон сая дөрвөн зуун далан дөрвөн мянга гурван зуун далан) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Ахлах нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Ц.Төрхүү)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500362

Нийслэлийн өмчийн харилцааны газрын  
 2024 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн  
 1150 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн өмчийн харилцааны газар

№	Эд хогшлын нэр	Хэмжээ хялж	Тоо ширхэг	Ашигласан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллага
1	Дэлгэц 24 инч dell-1	Ш	5	2022	648,120.00	3,240,600.00	1,761,195.62	1,479,404.38	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
2	Процессор Dell optilex 5090	Ш	5	2022	2,340,800.00	11,704,000.00	5,088,695.48	6,615,304.52		
3	Принтер өнгөт Lazer HP M452NW	Ш	2	2022	1,264,885.00	2,529,770.00	1,897,327.44	632,442.56		
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн						17,474,370.00	8,747,218.54	8,727,151.46		